<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	174,432,100.00	55,027,208.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.00	55,027,208.75
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,432,100.00	00.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	89,277,415.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	21,389,885.75
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	787	613
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	6	6
610001	Төсвийн байгууллага	6	6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	119	115
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	62	57
620003	Үйлчлэх ажилтан	37	38
620004	Гэрээт ажилтан	9	9
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	543	377
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	385	247
630001	Төрийн өмчит ЕБС	385	247
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	158	130
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	158	130
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>119</b>	<b>115</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	32	28
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	16
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	49	52
650010	Гэрээт ажилтан	0	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

### **3. АУДИТЫН ТАЙЛАН**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч А.Даваадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шилэн дансны мэдээлэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 22-оос 2021 оны 03 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Төв аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэв.

Төв аймгийн Баянцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн Аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05/17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Төв аймгийн Баянцогт сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орон нутагтаа бүх шатны Хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн сумын тогтвортой хөгжлийг хангана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Орон нутагтаа бүх шатны Хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх
- Мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**



Төв аймгийн Баянцогт сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Баянцогт сумын төсөвт байгууллагууд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба нь 2020 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу 15 сумын 101, аймгийн төвийн 17, нийт 118 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн талаар Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.03.02-ны өдрийн 33/18 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Шалгалтад хамрагдсан байгууллагад илэрсэн зөрчилд албан шаардлага, төлбөрийн акт тогтоон ажилласан зөрчлийн судалгааг ирүүлсэн боловч, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар ямар ч мэдээлэл ирүүлээгүй байна. Тус сумын төсөвт байгууллагууд нь уг хяналт шалгалтад хамрагдаагүй байна.

Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, аймгийн СТСХ-ээс сумдын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргын удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, сум байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч аймгийн хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна.

Төв аймгийн Баянцогт сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай гэж үнэлж байна.

### **3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “ДУНД” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлого 1,973,859.4 мянган төгрөгийн 1 хувь буюу 19,738.6 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг эхний хагас жилийн санхүүгийн үзүүлэлтээс тооцсон тул өөрчлөх шаардлагатай гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлого 2,365,475.1 мянган төгрөгөөс

23,654.6 мянган төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын 1 хувийг хэвээр сонгосонтой холбоотой болно.

### 3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 161,015.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 136,084.7 мянган төгрөг болж, 24,931.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ Бууралт /-/	Эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	120,532.92	89,494.15	(31,038.77)	65.76
Арилжааны банк дахь харилцах	40,482.83	46,590.64	6,107.81	34.24
<b>Нийт дүн</b>	<b>161,015.76</b>	<b>136,084.79</b>	<b>(24,930.97)</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 89,494.2 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 46,590.6 мянган төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Үүнээс орон нутгийн хөгжлийн сан 8,136.0 мянган төгрөг, ерөнхий орлогын харилцахын үлдэгдэл 60,692.2 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн харилцахын үлдэгдэл 13,253.8 мянган төгрөг, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн харилцахын үлдэгдэл 7,412.1 мянган төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Төсөвт байгууллага нь харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг татварын Е баримтаар баталгаажуулахгүй байна. Тухайлбал ЗДТГ 36,989.1 мянган төгрөг, ИТХ 5,790.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн төв 21,090.4 мянган төгрөг, Соёлын төв 5,598.4 мянган төгрөгийн худалдан авалтыг Е баримтаар баталгаажуулаагүй байна.

#### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 230,630.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 322,381.2 мянган төгрөг болж, 91,750.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ Бууралт /-/	Эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	23.15	-	(23.15)	-
Байгууллагаас авах авлага	786.69	19,780.51	18,993.82	6.14
Хувь хүмүүсээс авах авлага	229,820.55	302,600.69	72,780.14	93.86
<b>Нийт дүн</b>	<b>230,630.38</b>	<b>322,381.19</b>	<b>91,750.81</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагаас авах авлагын үлдэгдэлд СХС-ийн зээл, хүүгийн авлага 93,9 хувийг, ОНХС-гийн 18,718.0 мянган төгрөгийн, Эмйн эргэлтийн сан 1,062.5 мянган төгрөгийн авлага 0,3 хувийг эзэлж байна.

Сум хөгжүүлэх сангийн дараах авлага хугацаа хэтэрсэн байна. Үүнд:

- 41 иргэнтэй холбоотой 147,885.0 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн
- 17,686.0 мянган төгрөгийн 6 иргэний авлагыг шүүхэд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-ийн ирүүлсэн авлагын үлдэгдэлтэй тулгахад 134,594.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх санхүүгийн санхүүгийн тайланд 35 иргэнтэй холбоотой 130,198.9 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн зөрчилд албан шаардлага бичигдсэн.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний 07 тоот тогтоолоор үйл ажиллагааны зардалд 1,500.0 мянган төгрөг зарцуулахаар баталсан. Гүйцэтгэлээр 2,101.9 мянган төгрөг зарцуулж, 601.9 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан зөрчилд албан шаардлага бичигдсэн.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд эхний болон эцсийн үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 129,826.77 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 139,839.9 мянган төгрөг болж, 10,013.22 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ Бууралт -/	Эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	18,457.32	23,970.27	5,512.95	17.14
Эм боох материал	19,234.85	29,277.82	10,042.97	20.94
Бичиг хэргийн материал	1,708.60	1,910.70	202.10	1.37
Аж ахуйн материал	65,681.69	72,151.73	6,470.04	51.60
Сэлбэг хэрэгсэл	238.50	120.00	(118.50)	0.09
Хүнсний материал	9,398.87	3,284.47	(6,114.40)	2.35
Бусад хангамжийн материал	13,731.94	7,750.00	(5,981.94)	5.54
Мал амьтад	1,375.00	1,375.00	-	0.98
<b>Нийт дүн</b>	<b>129,826.77</b>	<b>139,839.98</b>	<b>10,013.22</b>	<b>82.86</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 33,568.14 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны батлагдсан төсвийн зардалд сумдын эм, эмнэлгийн хэрэгслийн төсөв батлагдаж, бэлтгэн нийлүүлэлт оройтсон, мөн цар тахлаас урьдчилан сэргийлэх материал нөөц бүрдүүлснээс эм боох материалын үлдэгдэл 10,042.9 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 6,470.0 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын материал 5,512.9 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,288,963.22 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,226,709.03 мянган төгрөг болж, 62,254.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ Бууралт /-/	Эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	3,026,515.91	3,064,245.90	37,729.99	94.17
Хуримтлагдсан элэгдэл	(261,178.16)	(401,786.22)	(140,608.06)	(12.35)
Авто-тээврийн хэрэгсэл	139,217.07	139,217.07	-	4.28
Хуримтлагдсан элэгдэл	(124,504.74)	(130,612.74)	(6,108.00)	(4.01)
Машин тоног төхөөрөмж	442,075.42	470,415.60	28,340.18	14.46
Хуримтлагдсан элэгдэл	(283,415.82)	(311,282.52)	(27,866.71)	(9.57)
Тавилга, аж ахуйн эд хогшил	253,859.95	258,234.54	4,374.59	7.94
Хуримтлагдсан элэгдэл	(103,661.09)	(121,469.41)	(17,808.32)	(3.73)
Зам, гүүрийн байгууламж	151,535.66	151,535.66	-	4.66
Хуримтлагдсан элэгдэл	(8,452.26)	(16,904.52)	(8,452.26)	(0.52)
Бусад үндсэн хөрөнгө	70,250.37	65,649.81	(4,600.57)	2.02
Хуримтлагдсан элэгдэл	(32,377.41)	(31,400.00)	977.41	(0.97)
Програм хангамж	3,005.30	2,730.30	(275.00)	0.08
Хуримтлагдсан элэгдэл	(1,987.03)	(1,882.06)	104.97	(0.06)
Бусад биет бус хөрөнгө	117,170.00	117,170.00	-	3.60
<b>Нийт дүн</b>	<b>3,388,053.18</b>	<b>3,253,861.40</b>	<b>(134,191.78)</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 18,567.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 73,809.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 26,807.9 мянган төгрөгөөр хасагдсан байна. Тайлант онд 219,722.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурах шалтгаан болжээ.

Аудитын илрүүлэлт:

Төсөвт байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, шаардлага хангахгүй хөрөнгийг актлах талаар шийдвэрлээгүй байна. Тухайлбал ЭМТ 148,937.7 мянган төгрөг, Соёлын төв 15,283.8 мянган төгрөг, ЗДТГ 284,647.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 105.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж үлдэгдэлгүй байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ Бууралт /-/	Эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	105.00	-	(105.00)	-
Байгууллагад төлөх өглөг	-	-	-	-
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>105.00</b>	<b>-</b>	<b>(105.00)</b>	<b>-</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,918,441.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3,853.267.4 мянган төгрөг болж, 65,173.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ Бууралт -/	Эзлэх хувь
Өмч: - төрийн	1,573,125.53	1,573,125.53	-	40.83
Өмнөх үеийн үр дүн	274,525.13	1,108,955.05	834,429.91	28.78
Тайлант үеийн үр дүн	832,678.09	(65,173.72)	(897,851.81)	(1.69)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,238,112.33	1,236,360.51	(1,751.82)	32.09
<b>Нийт дүн</b>	<b>3,918,441.09</b>	<b>3,853,267.37</b>	<b>(65,173.72)</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 65,173.72 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ. **Үүнд:**

- Хуримтлагдсан үр дүн 1,043,781.3 мянган төгрөг болж, 65,173.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор орон нутгийн төсвийн өөрийн орлого 200.0 мянган төгрөг, түрээсийн орлого 2,194.6 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 128.7 хувиар биелсэн боловч 14 нэр төрлийн орлогоос 5 нэр төрлийн орлого 4,648.8 мянган төгрөгөөр буюу 0,1-62,6 хувиар тасарсан зөрчилд зөвлөмж өгөгдсөн

### 3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой төсвийн үр ашиггүй, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан зөрчлүүд, худалдан авах ажиллагаа гэх мэт зөрчлүүд илрээгүй болно.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагууд нь худалдан авалтын Төлбөрийн баримтыг QR кодоор баталгаажуулаагүй зөрчилд төсөвт байгууллагуудад зөвлөмж өгөгдсөн.

ЗДТГ, ЭМТ, Соёлын төв нь орон тооны цомхотголд орсон ажилчдад тэтгэмж олгохдоо цалингийн зардлаас олгосон зөрчилд албан шаардлага бичигдсэн.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын "тодотгосон төсөв батлах тухай" 2020.12.10-ны өдрийн 02 тоот тогтоолын 1-д зааснаар тайлант онд татварын 55,036.3 мянган төгрөгийн, татварын бус 21,100.0 мянган төгрөгийн, нийт 76,136.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, татварын байцаагчийн мэдээний гүйцэтгэлээр 97,989.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 128,7 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрөх орлого 17,757.8 мянган төгрөгөөр давсан нь урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого 19,651.5 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 541.1 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 113.4 мянган төгрөгөөр давсан ба газрын төлбөр 2,174.5 мянган төгрөгөөр, ус, рашаан нөөц ашигласны төлбөр 187.9 мянган төгрөгөөр тасарсан нь нөлөөлсөн байна.

Орлогын төлөвлөгөө нь ноос арьс ширний урамшууллаас суутгасан албан татвар орж ирсэн холбоотойгоор давж биелсэн байна.

Хүснэгт 2. Орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+/ Бууралт /-/	Эзлэх хувь
Үйл ажиллагааны орлого	9,000.0	9,541.1	541.1	106.0
Хөрөнгийн орлого	14,428.0	14,315.9	(112.1)	99.2
Хөрөнгө борлуулсны орлого	1,000.0	343.0	(657.0)	34.3
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	2,800.0	22,451.5	19,651.5	801.8
Бууны албан татвар	690.0	720.0	30.0	104.3
Улсын тэмдэгтийн хураамж	1,200.0	1,313.4	113.4	109.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,500.0	2,776.5	276.5	111.1
Ойн нөөц ашигласны төлбөр	4,000.0	4,276.8	276.8	106.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	300.0	112.1	(187.9)	37.4
Газрын төлбөр	19,118.3	16,943.8	(2,174.5)	88.6
Торгуулийн орлого	17,000.0	22,800.5	5,800.5	134.1
Төсөвт газрын өөрийн орлого	200.0	200.0	-	100.0
Нэр зааж ангилагдаагүй	1,500.0	-	(1,500.0)	-
Түрээсийн орлого	2,400.0	2,194.7	(205.4)	91.4
<b>Нийт дүн</b>	<b>76,136.3</b>	<b>97,989.3</b>	<b>21,853.0</b>	<b>128.7</b>

Эх сурвалж: Баянцогт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.6.7 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 398,460.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 2,480,019.6 мянган төгрөгөөр баталсан

байна. Энэ нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай тогтмол зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

### **3.6.8 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,480,019.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,317,208.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 95,810.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 67,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,480,019.6 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,504,282.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 827,823.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26,614.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 121,300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого, зээлийн эргэн төлөлт, урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,297,900.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 827,577.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15,854.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 33,189.07 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу эргэж төлөгдсөн зээлээс, нийт 2,174,521.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 305,497.8 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Энэ нь Орон нутгийн төсвөөс харьяа байгууллагуудад олгох санхүүжилтийг 242.62 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 10,759.1 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлого, эргэн төлөгдөх зээлийн эх үүсвэр 88,103.9 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,143,965.9 мянган төгрөг буюу 86,5 хувьтай байгаа нь урсгал үйл ажиллагааны зардлыг 264,886.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 52,410.9 мянган төгрөгөөр, эргэн төлөгдөх зээлийг 18,755.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна. Үүнд:

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 135,347.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.6.9 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 77,760.86 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10,531.75 мянган төгрөг, нийт 88,292.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 55,064.7 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 33,227.0 мянган төгрөг, нийт 88,292.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **3.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс 20 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна. Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл хэсэгт зөвхөн орон нутгийн орлогыг мэдээлсэн байна.

### **3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төсвийн орлогын бүрдүүлэлт, НББ-ийн бодлогын баримт бичигтэй холбоотой 2 зөвлөмж өгөгдсөн байна. Аудит хийх явцад татварын орлогыг нийт дүнгээр биелүүлж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан, НБББББ-тэй холбоотой зөвлөмж хэрэгжээгүй байна.

### **3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай зориулалттай сан, орон нутгийн төсвийн ерөнхий орлого, нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 төсвийн байгууллагад дүгнэлт гаргаж, 4 тусгай сангийн тайлан түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 6 байгууллагын санхүүгийн тайлангаас 6 байгууллагад "Зөрчилгүй" санал дүгнэлт өгөгдсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 668,613.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 126,124.3 мянган төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 339,137.6 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 203,351.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

#### **3.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн илрүүлэлт**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тусгай сангуудын аудитаар нийт 265,395.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 130,800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 134,594.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүллээ.

#### **3.9.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг үнэн зөв нэгтгэсэн байна.

### **3.10 ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД ХҮРГҮҮЛСЭН АКТ, АЛБАН ШААРДЛАГА**

Төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй.

### **3.11 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД БАЙДЛААР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ /ТУСГАЙ ЗОРИУЛАЛТТАЙ САНГИЙН АУДИТААР/**

#### **СХС-ийн аудитаар**



Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд 35 иргэнтэй холбоотой 130,198.9 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 601.9 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 4.7 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

### **3.11.1 Аудитын зөвлөмж**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 67,751.7 мянган төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

### **3.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Сум хөгжүүлэх сангийн 121,396.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт, шилэн дансны мэдээлэл, худалдан авалтын төлбөрийн баримтыг тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулахтай холбогдсон зөрчлийг таслан зогсоох тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. **Үүнд:**

### **4.1 Төсвийн орлоготой холбоотой асуудал**

#### **4.1.1 Илрүүлэлт:**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 128.7 хувиар биелсэн боловч 14 нэр төрлийн орлогоос 5 нэр төрлийн орлого 4,648.8 мянган төгрөгөөр буюу 0,1-62,6 хувиар тасарсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх 23 дугаар зүйлийн 23.8-д "Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.8.1-д "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар", гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **4.1.2 Эрсдэл:**

Төсвийн орлого тасарснаар төрийн чиг үүрэг болон ЗД-ын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр хэрэгжихгүй байх

#### **4.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж байх

#### **4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвшөөрсөн цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **4.2 Сум хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

#### **4.3.1 Илрүүлэлт:**

Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-ын ирүүлсэн авлагын үлдэгдэлтэй тулгахад 134,594.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "оршин байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **4.3.2 Эрсдэл:**

СХС-ийн жилийн эцсийн авлагын дүн судалгаа зөрүүтэй байх

#### **4.3.3 Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг үнэн зөв тайлагнах ба зээлдэгч бүрээр баталгаажуулах

#### **4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвшөөрсөн цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5.АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

<b>Огноо:</b> 2020.12.31	<b>Аудитын нэр:</b>	<b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	<b>Аудитын код:</b> ТӨА-2021/15/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Баянцогт сумын ТТЗ</b>		<b>Мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
1	Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд 35 иргэнтэй холбоотой 130,198.9 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 601.9 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн	130,800.8	Албан шаардлага өгөв	Засаг дарга Санхүү албаны дарга	А.Даваадорж Д.Батцэцэг	
2	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 128.7 хувиар биелсэн боловч 14 нэр төрлийн орлогоос 5 нэр төрлийн орлого 4,648.8 мянган төгрөгөөр буюу 0,1-62,6 хувиар тасарсан	4,648.8	Зөвлөмж	Засаг дарга Санхүү албаны дарга	А.Даваадорж Д.Батцэцэг	
3	Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-ын ирүүлсэн авлагын үлдэгдэлтэй тулгахад 52,699.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	134,594.6	Зөвлөмж өгөв	Засаг дарга Санхүү албаны дарга	А.Даваадорж Д.Батцэцэг	
<b>ДҮН</b>		<b>270,044.2</b>				

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Ц.ХИШИГЖАРГАЛ**

АУДИТЫН МЕНЕЖЕР **О.АМАРЖАРГАЛ**

АУДИТОР **Ж.БЯМБАЦОГТ**

**БЭЛТГЭСЭН:**

41174522  
НБД/10000000464

2021.03.20